



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 8/140/8/15

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6, 43 дугаар зүйлийн 43.3.3, “Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 3.3.6, 3.3.25 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний бичлэгийн системийг ашиглах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (П.Мөнхжаргал)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны даргын 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/529, А/11 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Д.Эрдэнэбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АЛТАНЦОМ

ДАРГА

Ж.ЦОЛМОН

Хянасан: Б.Мөнхбат
Боловсруулсан: Х.Одхүү
Нийлсэн: *Ц.Ариунзаяа* Ц.Ариунзаяа
2% Шив.Ж.О

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нислэг
техникийн осол, зөрчлийг шинжлэн
шалгах албаны даргын 2021 оны
дугаар сарын ... -ны өдрийн/.....дугаар
хамтарсан тушаалын хавсралт

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БИЧЛЭГИЙН СИСТЕМИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журам нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн 13 дугаар хавсралт, Иргэний нисэхийн тухай хууль, “Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийг тус тус үндэслэсэн болно.

1.2 Энэхүү журмын зорилго нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглаж буй дуун мэдээлэл, тоон өгөгдөл болон хяналтын камерын бичлэгийг хадгалах, хамгаалах, зөөвөрлөх, хэрэглэх, ашиглах, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧЛОЛ

2.1 *Хадгалах төхөөрөмж*- аналог болон тоон өгөгдлийг хадгалах боломжтой бүх төрлийн төхөөрөмжийг;

2.2 *Дуун мэдээлэл*- нислэгийн хөдөлгөөний удирдлагын дуу, ярианы өгөгдлийг агуулсан аналог болон тоон урсгалыг;

2.3 *Тоон өгөгдөл*- нислэгийн удирдагчийн автоматжуулсан ажлын байрны агаарын хөдөлгөөний удирдлагын дэлгэцээр илэрсэн агаарын хөлгийн байрлал, нислэгийн чиглэл, хөдөлгөөн, бусад мэдээлэл, нислэгийн удирдагчийн тоног төхөөрөмж дээр хийсэн үйлдлийн талаар мэдээлэл агуулсан тоон урсгалыг;

2.4 *Дүрс бичлэгийн төхөөрөмж*- Нислэгийн удирдагч, агаарын навигацийн тоног төхөөрөмжүүд дээр ажиллаж байгаа инженер техникийн ажилтнуудын ажлын байр болон бусад байршлуудад суурилагдсан хяналтын камеруудыг;

2.5 *Нисэх буудлын үйлчилгээ эрхлэгч*- Төв болон орон нутгийн нисэх буудлуудыг;

2.6 *Эрх бүхий этгээд*- Бичлэгийн төхөөрөмжийг хариуцан ажиллах томилогдсон инженер техникийн ажилтан

№	Товчлол	Тайлбар
1	ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
2	ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
3	НТОЗШША	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
4	НААХЗА	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба
5	ХНАҮБ	Холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээний байгууллага
6	НХҮБ	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага
7	НХҮ	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ
8	НХУ	Нислэгийн хөдөлгөөний удирдлага
9	SDD	Агаарын хөдөлгөөний удирдлагын дэлгэц (Situation Display Data)
10	ЭХАТМЗХ	Эрэн хайх авран туслах мэдээлэл зохицуулах хэсэг
11	ААНХХ	Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс
12	STCA	Мөргөлдөх аюулын анхааруулга (Short Term Conflict Alert)
13	НМҮБ	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага

ГУРАВ. БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖ БА СУВГУУД

3.1 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглаж буй бичлэгийн систем нь дараах төрлийн бичлэгийн төхөөрөмжүүдээс бүрдэнэ. Үүнд:

3.1.1 Холбооны дуун мэдээллийн бичлэг;

3.1.2 Дүрс буюу камерын бичлэг;

3.1.3 Ажиглалтын системийн Asterix форматын тоон мэдээллийн бичлэг;

3.1.4 Нислэгийн удирдагчийн ажлын байрны автоматжуулсан системийн өгөгдлийн тоон мэдээллийн бичлэг.

3.2 Дуун мэдээллийн бичлэгийн систем нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглаж буй хавсралт (А, Б, В, Г, Ж-1, Ж-3)-д заасан радио болон телефон холбооны сувгийн дуун мэдээллийг бичиж хадгална.

3.3 Ажиглалтын системүүдийн бичлэгийн төхөөрөмжүүд нь хавсралт (Д, Ж-2)-д заагдсан Радиолокаторын болон ADS-B системүүдийн агаарын хөлгийн илрүүлэлтийн Asterix болон Автоматжуулалтын системийн STCA (Violation)-мэдээллүүдийг бичиж хадгална.

3.4 Нислэгийн удирдагчийн автоматжуулсан ажлын байрны бичлэгийн систем нь бүх SDD ажлын байрны өгөгдлийг бичиж хадгална.

3.5 Дүрс бичлэгийн систем нь Хавсралт (Е)-д заасан байршлууд дахь хяналтын камерын мэдээллийг хадгална.

3.6 Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүдийн хооронд солилцсон автомат зөвшилцлийн (OLDI/AIDC) мэдээллийг нислэгийн өгөгдөл боловсруулах (FDP) систем дээр хадгална.

3.7 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглаж буй бичлэгийн систем нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

3.7.1 Бичлэгийн систем болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдаж буй цаг нь UTC цагаас 1 секундээс илүү зөрүүгүй байх;

3.7.2 Бичлэг нь дуун мэдээлэл болон тоон өгөгдлийг үнэн зөв хуулбарласан байх.

ДӨРӨВ. БИЧЛЭГИЙН СИСТЕМИЙН ХАМГААЛАЛТ, БИЧЛЭГИЙН ХАДГАЛАЛТ

4.1 ХНАҮБ нь "Чингис хаан" Олон улсын нисэх буудал болон "Буянт-Ухаа" нисэх буудлын нислэгийн хөдөлгөөний удирдлагын бичлэгийн төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах ба бичлэгийн тоног төхөөрөмж болон бичлэгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна.


4.2 Орон нутгийн нисэх буудал дахь бичлэгийн системийн хэвийн ажиллагааг хангах үүргийг нисэх буудлын үйлчилгээ эрхлэгч хүлээх ба бичлэгийн тоног төхөөрөмж, бичлэг бүхий хадгалах төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна. Хувийн нисэх буудал нь бичлэгийн төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, хадгалахтай холбоотой үйл ажиллагааны журмыг ХНАҮБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжүүлнэ.

4.3 Бичлэгийн төхөөрөмжийг зөвхөн эрх бүхий этгээд орох боломжтой лац бүхий өрөө эсвэл зогсуурт байрлуулж, бичлэг бүхий хадгалах төхөөрөмжийг цоож, лац бүхий сейфэнд хадгална.

4.4 Бичлэгийг хуулбарлан зөөвөрлөх тусгай хадгалах төхөөрөмж нь нэг удаагийн лац бүхий хайрцагтай байна.

4.5 Бичлэгийн төхөөрөмж нь халуун нөөцийн горимд ажиллах ба бичлэг хадгалах нэгж хэсгийн нөөцийг 90 хоногоос дээш бичлэг хийх багтаамжтай бэлэн байлгана.

4.6 Нислэгийн өгөгдөл боловсруулах систем (FDP) дээр 7 хоног тутам автоматаар үүсч буй Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүдийн хооронд



солилцсон автомат зөвшилцлийн (OLDI/AIDC) мэдээллийг агуулсан файлыг зөөврийн хатуу дискт хуулбарлан 90 хоног хадгална.

4.7 НТОЗШША, НХҮБ-аас ХНАҮБ-нд хүсэлт гаргаагүй бол бичлэгийг 90 хоног хадгалсны дараа устгаж, хадгалах төхөөрөмжийг дахин ашиглаж болно.

4.8 ХНАҮБ-ын дарга нь бичлэгийн тоног төхөөрөмжийн техник ашиглалтын зааврыг боловсруулан баталсан байна.

4.9 ХНАҮБ-ын дарга нь бичлэгийн төхөөрөмжийг хариуцан ажиллах инженер техникийн ажилтныг томилох ба тухайн ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгасан байна.

4.10 Бичлэгийн төхөөрөмжийг хариуцан ажиллах инженер техникийн ажилтан нь ХНАҮБ-аас баталсан техник ашиглалтын зааврыг мөрдөж ажиллана.

4.11 Бичлэг эхэлсэн ба дууссан хугацааг дахин ашигласан тоо зэргийг хариуцсан инженер техникийн ажилтан бүртгэж ХНАҮБ-ын дарга (орон нутагт нисэх буудлын дарга) хяналт тавьж ажиллана. Бичлэгийн системд холбогдсон телефон аппарат дээр "БИЧЛЭГТЭЙ" гэсэн анхааруулах тэмдэглэгээг байршуулна.

4.12 Хяналтын камер суурилагдсан ажлын байруудад "КАМЕР АЖИЛЛАЖ БАЙНА" анхааруулах тэмдэглэгээг байршуулна.

4.13 Бичлэгийн төхөөрөмжийг хариуцан ажиллах инженер техникийн ажилтан нь бичлэгийн системийн техникийн бэлэн байдлыг ханган ажиллах ба НТОЗШША-ны Ерөнхий шинжээчийн зөвшөөрлийн дагуу сонсох, үзэх, хуулбарлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

ТАВ. БИЧЛЭГИЙН АШИГЛАЛТ

5.1 Нислэг, техникийн ноцтой зөрчил, осолтой холбоотой бичлэгийг хуулбарлах эрхийг НТОЗШША-ны Ерөнхий шинжээч болон шинжээч нар эдэлнэ.

5.2 Нислэг, техникийн ноцтой зөрчил, осолтой холбогдох бичлэг бүхий хадгалах төхөөрөмжийг хураах эрхийг зөвхөн НТОЗШША-ны Ерөнхий шинжээч эдэлнэ.

5.3 Хадгалах төхөөрөмжийн бичлэгийг НТОЗШША-ны Ерөнхий шинжээчийн маягт /Хавсралт-3/-ын дагуу олгосон зөвшөөрлөөр устгаж, хадгалах төхөөрөмжийг дахин ашиглаж болно.

5.4 НААХЗА-ны ААНХХ-ийн Нислэгийн хөдөлгөөний хяналтын байцаагч нь ажлын шаардлагаар ажиглалтын удирдлагын бичлэгийг үзэх, телефон болон радио-холбооны бичлэг сонсох, хуулбарлах зэрэг хүсэлтийг маягт /Хавсралт-И/-ын дагуу гарган ААНХХ-ийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчаар баталгаажуулан авна.

5.5 НХҮБ-ын Аюулгүй ажиллагааны нэгжийн ажилтан нь энэхүү журмын 5.7-д зааснаас бусад бичлэгийг сонсох, үзэх, хуулбарлах эрхийг маягт /Хавсралт-3/-ын дагуу НТОЗШША-ны шинжээчээс дараах зорилгоор авна. Үүнд:

5.5.1 НХҮ-ний ажилтны ур чадварыг үнэлэх, нислэгийн хөдөлгөөний удирдлагад дүн шинжилгээ хийх зэрэг албаны дотоод үйл ажиллагаанд ашиглах;

5.5.2 Нислэгийн хөдөлгөөний удирдлагын секторын багтаамж, нэвтрэн өнгөрүүлэх чадварыг тооцоолох, тодорхойлох;

5.5.3 НХҮ-ний журам, технологийн ажиллагаа хэвийн эсэхийг хянах.

5.6 ХНАҮБ-ын Аюулгүй ажиллагааны нэгжийн ажилтан нь энэхүү журмын 5.7-д зааснаас бусад бичлэгийг сонсох, үзэх, хуулбарлах эрхийг маягт /Хавсралт-3/-ын дагуу НТОЗШША-ны шинжээчээс дараах зорилгоор авна. Үүнд:

5.6.1 Аливаа технологийн маргааныг шийдвэрлэх, дүгнэлт гаргах

5.6.2 Техник, технологийн ажиллагаа хэвийн эсэхийг хянах

5.7 НТОЗШША-ны Ерөнхий шинжээч эрх олгосноос бусад тохиолдолд дотоод үйл ажиллагаанд дараах бичлэгүүдийг ашиглахыг хориглоно. Үүнд:

5.7.1 Нислэг-техникийн осол, ноцтой зөрчилтэй холбоотой бичлэг;

5.7.2 НТОЗШША, НХҮБ-аас цаашид хадгалах хүсэлт гаргасан бичлэг.

5.8. Зөвшөөрлөөр бичлэг хуулбарлан авсан этгээд бичлэгийг зөвхөн зөвшөөрөл олгогдсон зорилгоор хэрэглэх бөгөөд дахин хуулбарлах, хувиан олшруулах, тараахыг хориглоно.

5.9. Хуулбарлан авсан болон үзсэн, сонссон бичлэгийн нууцлал хадгалах хариуцлагыг тухайн этгээд хүлээнэ. Хариуцлага алдсан этгээдэд хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. БИЧЛЭГИЙГ ЗӨӨВӨРЛӨХ

6.1. Тус журмын 5.1-д заасны дагуу бичлэгийг хуулбарлан өгөхдөө бичлэгийн төхөөрөмж хариуцсан инженер нь бичлэгтэй зөөврийн флаш дискийг агуулсан лацтай хайрцгийг 5.1-д заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө.

6.2. Бичлэгийн төхөөрөмж хариуцсан инженер нь бичлэгтэй зөөврийн флаш дискийг агуулсан лац бүхий хайрцгийг хүлээлгэж өгөх боломжгүй бол баталгаат шуудангаар НТОЗШША-ны Ерөнхий шинжээчид хүргүүлнэ.

ДОЛОО. БИЧЛЭГИЙН БҮРТГЭЛ

7.1. Бичлэгийн төхөөрөмж хариуцсан инженер техникийн ажилтан нь бичлэгийг үзсэн, сонссон, эх хувийг хуулбарласан албан тушаалтнаар бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна.

7.2. Бичлэгийн төхөөрөмж хариуцсан инженер техникийн ажилтан нь бичлэг хуулбарласан, үзсэн, сонссон тухай тайланг улирал бүр НТОЗШША-ны шинжээчид хүргэж байна.

7.3. НААХЗА-ны Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс болон ИНҮТ-ийн НХҮБ, ХНАҮБ-ын нэгжүүд нь бичлэг сонссон, үзсэн, дүгнэсэн тайланг гарган хагас жил тутам НТОЗШША-нд хүргүүлж байна.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1 Энэхүү журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ХНАҮБ нь НТОЗШША болон ИНЕГ-аас холбогдох саналыг авч боловсруулан ИНЕГ, НТОЗШША-ны даргаар батлуулна.

8.2 Энэхүү журмын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах (утас, радио холбооны суваг)

8.3 Ажиглалтын системүүдийн болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажлын байрыг бичлэгийн системд шинээр холбох болон холболтоос хасах тохиолдолд) байгууллага нь НТОЗШША-нд албан бичгээр хүсэлтээ гаргаж, зөвшөөрсөн тохиолдолд ХНАҮБ нь зохих өөрчлөлтийг оруулж, өөрчлөлтийн бүртгэлээр баталгаажуулна.

8.4 Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд холбогдох хууль, дүрэм, журамд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

**НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВИЙН
ДУУ БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН СУВГИЙН ЖАГСААЛТ**

Хавсралт-А(1)

GAREX 220 (Radio)

№	СУВГИЙН НЭР	ТАЙЛБАР	№	СУВГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	Алтай 122,5 МГц	Radio VHF	22	Мөрөн 128,0 МГц	Radio VHF
2	Алтай 124,0 МГц	Radio VHF	23	Бор-Өндөр 126,5 МГц	Radio VHF
3	Арвайхээр 127,0 МГц	Radio VHF	24	Өндөрхаан 126,0 МГц	Radio VHF
4	Арвайхээр 122,5 МГц	Radio VHF	25	Сайхандулаан 121,5 МГц	Radio VHF
5	Их-Өлгий 121,5 МГц	Radio VHF	26	Сайхандулаан 127,0 МГц	Radio VHF
6	Их-Өлгий 126,5 МГц	Radio VHF	27	Сайншанд 127,0 МГц	Radio VHF
7	Бөмбөгөр 122,5 МГц	Radio VHF	28	Сайншанд 126,5 МГц	Radio VHF
8	Бөмбөгөр 121,5 МГц	Radio VHF	29	Тосонцэнгэл 124,0 МГц	Radio VHF
9	Богд-Уул 120,0 МГц	Radio VHF	30	Ургамал 121,5 МГц	Radio VHF
10	Богд-Уул 132,0 МГц	Radio VHF	31	Ургамал 124,0 МГц	Radio VHF
11	Богд-Уул 121,5 МГц	Radio VHF	32	Ховд 124,0 МГц	Radio VHF
12	Богд-Уул 126,0 МГц	Radio VHF	33	Ховд 121,5 МГц	Radio VHF
13	Мөнх-Өлзийт 127,0 МГц	Radio VHF	34	Чойбалсан 121,5 МГц	Radio VHF
14	Булган 126,0 МГц	Radio VHF	35	Чойбалсан 126,5 МГц	Radio VHF
15	Булган 128,0 МГц	Radio VHF	36	Хэнгэрэгтэй 128,0 МГц	Radio VHF
16	Далан 122,5 МГц	Radio VHF	37	Хэнгэрэгтэй 121,5 МГц	Radio VHF
17	Далан 127,0 МГц	Radio VHF	38	Мөнх-Өлзийт 120,0 МГц	Radio VHF
18	Баянтээг 127,0 МГц	Radio VHF	39	Улаангом 121,5 МГц	Radio VHF
19	Баянтээг 121,5 МГц	Radio VHF	40	Улаангом 124,0 МГц	Radio VHF
20	Мандалговь 127,0 МГц	Radio VHF			
21	Мандалговь 126,5 МГц	Radio VHF			

---000---

GAREX 220 (Position)

№	АЖЛЫН БАЙРНЫ НЭР	ТАЙЛБАР	№	АЖЛЫН БАЙРНЫ НЭР	ТАЙЛБАР
1	TWR-2	Цамхаг	12	Говь-2	Сектор
2	AFTN	Нислэгийн өгөгдөл	13	SUP ACC-1	Ерөнхий нислэгийн удирдагч
3	Баян-1	Сектор	14	SUP ACC-2	
4	COD	Нислэгийн өгөгдөл	15	APP-2	Ойртолтын НХУ
5	Алтай-1	Сектор	16	TECH	Хяналт
6	Алтай-2	Сектор	17	Баян-2	Сектор
7	Мөрөн-1	Сектор	18	TWR-1	Цамхаг
8	Мөрөн-2	Сектор	19	Төв-1	Сектор
9	Дорнод-1	Сектор	20	Төв-2	Сектор
10	RCC	Эрэн хайх	21	Дорнод-2	Сектор
11	Говь-1	Сектор	22	APP-1	Ойртолтын НХУ

S4 Controller (Position)

№	АЖЛЫН БАЙРНЫ НЭР	ТАЙЛБАР	№	АЖЛЫН БАЙРНЫ НЭР	ТАЙЛБАР
1	Tech	Хяналт	5	Төв	Сектор
2	APP	Ойртолтын НХУ	6	Алтай	Сектор
3	Мөрөн	Сектор	7	Говь	Сектор
4	Дорнод	Сектор			

GAREX 220 (Telephone)

№	УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР	№	УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	1141	Shift officer	10	1134	AFTN
2	1142	Алтай сектор	11	1135	SUP
3	1140	Дорнод сектор	12	1176	APP
4	1137	APP	13	1130	Баян сектор
5	NOTAM /шууд/	Hotline	14	0086-10-64593674 0086-10-64305076 701	Бээжин хотын НХУ-ын төв
6	1139	RCC	15	0086-471-4941331 0086-471-4951900 0086-471-3383229	Хөх хотын НХУ-ын төв
7	1131	Говь сектор	16	0086-931-8168332 0086-931-8166213 0086-931-8168338	Ланжоу хотын НХУ-ын төв
8	1136	Aerodrome TWR	17	+73952522924 +73952563866 903866, 902927 903805, 902903 802903, 902924 +73952563805 +73952563804 +73952563831	Эрхүү хотын НХУ-ын төв
9	1138	RCC Position	18	+73912526714 230202	Красноярск НХУ-ын төв
10	1179	APP-2	22	5405458	Новосибирск хотын НХУ-ын төв

11	1132	УБ сектор	23	0086-470-8272085 0086-470-8215150 0086-470-3572201	Хайлар хотын НХУ-ын төв
12	1133	Мөрөн сектор	24	0086-991-3809607 0086-991-3806023 0086-991-3809603	Өрөмч хотын НХУ-ын төв



---000---



ТООН УТАС

№	УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	7128-1675	НХҮБ-ын ээлжийн өмнөх болон дараах ярианы өрөө
2	7128-1603	ХНАҮБ-ын Холбооны хэсгийн ээлжийн инженер
3	7128-1604	ХНАҮБ-ын Ээлжийн ахлагч инженер
4	7128-1648	ХНАҮБ-ын Цахилгааны хэсгийн ээлжийн инженер
5	7128-1654	ХНАҮБ-ын Навигацийн хэсгийн ээлжийн инженер
6	7128-1611	НХҮБ-ын Цамхагийн нислэгийн удирдагч
7	7128-1618	НХҮБ-ын Бүсийн нислэгийн удирдагч
8	7128-1635	НХҮБ-ын Нислэгийн мэдээллийн төв
9	7128-1691	НХҮБ-ын ЭХАТМЗХ-ийн ээлжийн ажилтан
10	7128-1622	НХҮБ-ын ЭХАТМЗХ-ийн ээлжийн ажилтан
11	7128-1637	НХҮБ-ын Нислэгийн мэдээллийн төв
12	7128-1602	НХҮБ-ын Шуурхай төлөвлөлтийн ээлжийн ажилтан
13	7128-1700	НХҮБ-ын дарга
14	7128-1613	НХҮБ-ын менежер
15	7128-1614	НХҮБ-ын Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын хэсгийн дарга
16	7128-1710	НХҮБ-ын Ойртолтын бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын хэсгийн дарга
17	7128-1723	ХНАҮБ-ын Ажиглалтын хэсгийн ээлжийн инженер
18	7128-1724	ХНАҮБ-ын Ажиглалтын хэсгийн ээлжийн инженер
19	7128-3102	НМУБ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний илтгэх төв
20	7128-1601	ХНАҮБ-ын Холбооны хэсгийн ээлжийн инженер
21	7128-1605	ХНАҮБ-ын Холбооны хэсгийн ээлжийн инженер

АНАЛОГ УТАС

№	УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	7128-3215	Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Нислэгийн цаг уурын төв
2	7128-1150	ХНАҮБ-ын нислэгийн ярианы бичлэгийн системийн техникч
3	7128-3235	Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Нислэгийн цаг уурын төв
4	Микрофон	ХНАҮБ-ын ээлжийн ярианы өрөөний чанга яригч
5	7128-3217	НМУБ-ын ээлжийн ахлагч
6	7128-3264	НМУБ-ын мэдээллийн үйлчилгээний ажилтан
7	70047340	НХҮБ-ын Ерөнхий нислэгийн удирдагч
8	7128-5514	НМУБ-ын мэдээллийн мэргэжилтэн
9	70049785	ХНАҮБ-ын ээлжийн ахлагч инженер
10	7128-3230	ХНАҮБ-ын суултын системийн төхөөрөмжийн өрөө
11	7128-3208	Аэродром, барилга байгууламж ашиглалтын албаны ээлжийн инженер
12	7128-5038	ХНАҮБ-ын цахилгааны дэд өртөөний (ТП-2Б) ээлжийн инженер
13	70049984	Цамхагийн нислэгийн удирдагчийн нөөц ажлын байр

ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН
БАЙРНЫ ДУУ БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН
СУВГИЙН ЖАГСААЛТ

VHF & HF (Backup Radio)

№	СУВГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	Морин Уул 120,0МГц	Radio VHF (Backup VHF radio)
2	Морин Уул 126,0 МГц	Radio VHF (Backup VHF radio)
3	5680 КГц /R&S/	Radio HF (Emergency HF radio)
4	Арцат 5715 КГц Tx	Radio HF
5	Арцат 5715 КГц Rx	Radio HF
6	Туул 5505 КГц Tx	Radio HF
7	Туул 5505 КГц Rx	Radio HF

ЭФИР

№	СУВГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	Мөнх-Өлзийт 127,0 МГц	Radio VHF
2	Богд-Уул 126,0 МГц	Radio VHF
3	Морин-Уул 126,0 МГц	Radio VHF
4	Богд-Уул 121,9 МГц	Radio VHF
5	Богд-Уул 132,0 МГц	Radio VHF
6	Богд-Уул 121,5 МГц	Radio VHF
7	Морин-Уул 120,0 МГц	Radio VHF

УТАС


№	УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	7128-1147	ХНАҮБ-ын Азимутын радио дохиологч ба зай хэмжих төхөөрөмжийн байр (VOR, DME)
2	7128-1185	ХНАҮБ-ын холын чиглүүлэх станцын өрөө
3	7128-1159	ХНАҮБ-ын цахилгааны дэд өртөө (ЗБ)
4	Notam шууд утас	Hotline
5	7128-1901	Их-Өлгий (оптик утас)
6	7128-1902	Мөнх-Өлзийт (оптик утас)
7	7128-1903	Бор-Өндөр (оптик утас)
8	7128-1904	Хэнгэрэгтэй (оптик утас)
9	7128-1905	Бөмбөгөр (оптик утас)
10	7128-1906	Сайхандулаан (оптик утас)
11	7128-1907	Баянтээг (оптик утас)

НХҮБ-ЫН ОЙРТОЛТЫН НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН НӨӨЦ
АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ДУУ БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН СУВГИЙН
ЖАГСААЛТ

VHF /HF РАДИО & УТАС

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Ground Control 121,5 МГц	Radio VHF
2	Ground movement 121,9 МГц	Radio VHF
3	Ground Control 132,0 МГц	Radio VHF
4	Ground Control 126,0 МГц	Radio VHF
5	7128-5513	Телефон дугаар
6	7128-5526	Телефон дугаар

---000---



ОРОН НУТГИЙН НИСЭХ БУУДЛУУД ДАХЬ
ДУУ БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН СУВГИЙН ЖАГСААЛТ

а. ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Арцат 5715 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
2	Цамхаг 130,0 МГц	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
3	RCAG 128,0 МГц	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
4	7128-1208	Нислэгийн удирдагч
5	Ярианы өрөө	Нислэгийн ярианы бичлэг

б. САЙНШАНДЫН ОЛОН УЛСЫН ӨНГӨРӨЛТИЙН ЦЭГИЙН БИЧЛЭГИЙН СИСТЕМИЙН СУВГИЙН ЖАГСААЛТ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	RCAG 126,5 МГц	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
2	RCAG 127,0 МГц	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
3	7128-1204	Нислэгийн удирдагч

в. ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Туул 5505 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
2	RCAG 126,5 МГц	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
3	Цамхаг 130,0 МГц (үндсэн)	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
4	Emergency 121,5 МГц	Онцгой нөхцөл үүсэх үед ашиглах радио холбоо
5	7128-1194	Нислэгийн удирдагч
6	Цамхаг 130,0 МГц (нөөц)	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо /нөөц/

г. ХОВД АЙМГИЙН ХОВД НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	7128-1202	Нислэгийн удирдагч
2	7128-1211	Ховд нисэх буудлын холбооны инженер
3	Арцат 5715 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
4	Цамхаг 130,0 МГц	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
5	RCAG 124,0 МГц	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо

д. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Арцат 5715 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо

2	Цамхаг 130,0 МГц	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
3	Барнаул 6270 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
4	7128-1172	Нислэгийн удирдагч

ж. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБУМБАТ НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Туул 5505 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
2	Цамхаг 131,0 МГц	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
3	7128-6136	Нислэгийн удирдагч

з. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТАВАНТОЛГОЙ НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Туул 5505 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
2	Цамхаг 132,0 МГц	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо

и. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	Туул 5505 КГц	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
2	7128-6153	Гурвансайхан нисэх буудлын холбооны инженер
3	Цамхаг 129,0 МГц	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
4	7128-1210	Нислэгийн удирдагч
5	70532657	Гурвансайхан нисэх буудал

й. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЛТАЙ НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	7128-6127	Алтай нисэх буудлын холбооны инженер
2	7128-1200	Нислэгийн удирдагч
3	Цамхаг 130,0МГц (үндсэн)	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
4	Цамхаг 130,0МГц (нөөц)	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
5	HF 5715КГц Тх	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
6	HF 5715КГц Rx	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо

к. УВС АЙМГИЙН ДЭГЛИЙ ЦАГААН НИСЭХ БУУДАЛ

№	СУВГИЙН НЭР / УТАСНЫ ДУГААР	ТАЙЛБАР
1	7128-6126	Дэглий цагаан нисэх буудлын холбооны инженер
2	7128-1201	Нислэгийн удирдагч
3	Цамхаг 130,0МГц (үндсэн)	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
4	Цамхаг 130,0МГц (нөөц)	Аэродромын (цамхаг) нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио холбоо
5	HF 5715КГц Тх	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо
6	HF 5715КГц Rx	Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний радио холбоо

Хавсралт-Д

АЖИГЛАЛТЫН СИСТЕМИЙН БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

Хавсралт-Д(1)

GDR/ РАДИОЛОКАТОРУУДЫН БИЧЛЭГИЙН ЖАГСААЛТ

№	РАДИОЛОКАТОРЫН НЭР	ТАЙЛБАР
1	Хэнгэрэгтэй	Asterix data
2	Мөнх-Өлзийт	Asterix data
3	Бор-Өндөр	Asterix data
4	Баянтээг	Asterix data
5	Их-Өлгий	Asterix data
6	Сайхандулаан	Asterix data
7	Бөмбөгөр	Asterix data

Хавсралт-Д(2)

GDR/ РАДИОЛОКАТОРУУДЫН УХТ-Н БИЧЛЭГИЙН ЖАГСААЛТ

№	РАДИОЛОКАТОРЫН НЭР	ТАЙЛБАР
1	Хэнгэрэгтэй	Optic/Asterixdata
		VSAT/Asterix data
2	Мөнх-Өлзийт	Optic/Asterix data
		VSAT/Asterix data
3	Бор-Өндөр	Optic/Asterix data
		VSAT/Asterix data
4	Баянтээг	Optic/Asterix data
		VSAT/Asterix data
5	Их-Өлгий	Optic/Asterix data
		VSAT/Asterix data
6	Сайхандулаан	Optic/Asterix data
		VSAT/Asterix data
7	Бөмбөгөр	Optic/Asterix data
		VSAT/Asterix data

Хавсралт-Д(3)

АВТОМАТ ЗӨВШИЛЦЛИЙН МЭДЭЭЛЛИЙН БИЧЛЭГ (OLDI/AIDC)

№	OLDI/AIDC-ИЙН НЭР	ТАЙЛБАР
1	НХУ-ын төвүүд хооронд солилцсон автомат зөвшилцлийн мэдээлэл	Нислэгийн өгөгдөл боловсруулах систем (FDP) дээр хадгална.

Хавсралт-Д(4)

STCA-МЭДЭЭЛЛИЙН БИЧЛЭГ (Short Term Conflict Alert)

№	STCA (VIOLATION)	ТАЙЛБАР
1	Short Term Conflict Alert	Aircon 2100 DRF бичлэгийн систем дээр хадгална.

GDR/ ADS-B УХТ-ийн БИЧЛЭГИЙН ЖАГСААЛТ

№	ADS-B-ИЙН НЭР	ТАЙЛБАР	
		Optic VSAT	1-р хүлээн авагч
1	Улаанбаатар	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
2	Сайншанд	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
3	Хэнгэрэгтэй	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
4	Хэнтий	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
5	Их-Өлгий	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
6	Дорнод	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
7	Баянтээг	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
8	Бөмбөгөр	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
9	Ургамал	Optic VSAT	2-р хүлээн авагч
		Optic VSAT	1-р хүлээн авагч
10	Булган	Optic VSAT	
11	Далан	Optic VSAT	
12	Ховд	Optic VSAT	
		Optic VSAT	

ДҮРС БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	КАМЕРИЙН НЭР	КАМЕРИЙН БАЙРШИЛ
1	Төхөөрөмжийн өрөө 1	НХУ-ын төв
2	Тасралтгүй тэжээлийн өрөө (UPS) (2 давхар)	НХУ-ын төв
3	Цамхаг(ойртолтын нислэгийн удирдлагын өрөө)	НХУ-ын төв
4	Control (бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын өрөө)	НХУ-ын төв
5	Тасралтгүй тэжээлийн өрөө (UPS) (1 давхар)	НХУ-ын төв
6	Дотоод холбооны өрөө	НХУ-ын төв
7	Төхөөрөмжийн өрөө 2	НХУ-ын төв
8	Нислэгийн мэдээллийн төв - Арцат & Туул	НХУБ-ын Нислэгийн мэдээллийн төв
9	Diesel Generator-ийн өрөө	НХУ-ын төв
10	Ээлжийн инженерүүдийн өрөө	НХУ-ын төв
11	АХ-ийн ээлжийн инженерүүдийн өрөө	НХУ-ын төв
12	Мөрөн сектор	НХУ-ын төв
13	Төв сектор	НХУ-ын төв
14	Баян сектор	НХУ-ын төв
15	Далан сектор	НХУ-ын төв
16	Говь сектор	НХУ-ын төв
17	Нарны цахилгаан өрөө 1	Нарны цахилгаан станц
18	Нарны цахилгаан өрөө 2	Нарны цахилгаан станц
19	Нарны панель 1	Нарны цахилгаан станц
20	Нарны панель 2	Нарны цахилгаан станц
21	Нарны панель 3	Нарны цахилгаан станц
22	Нарны панель 4	Нарны цахилгаан станц
23	Нарны панель 5	Нарны цахилгаан станц
24	Нарны панель 6	Нарны цахилгаан станц
25	Нарны панель 7	Нарны цахилгаан станц
26	Нарны панель 8	Нарны цахилгаан станц
27	Хяналтын камер	Хэнгэрэгтэй радиолокатор
28	Хяналтын камер	Мөнх-Өлзийт радиолокатор
29	Хяналтын камер	Бор-Өндөр радиолокатор
30	Хяналтын камер	Баянтээг радиолокатор
31	Хяналтын камер	Их-Өлгий радиолокатор
32	Хяналтын камер	Сайхандулаан радиолокатор
33	Хяналтын камер	Бөмбөгөр радиолокатор

**“ЧИНГИС ХААН” ОУНБ-ЫН ДУУ БИЧЛЭГИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН
СУВГИЙН ЖАГСААЛТ**

Хавсралт-Ж(1)

COMPACT 3 GAREX 220 (Position)

№	СУВГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	TOWER-1	Нислэгийн удирдагч
2	TOWER-2	Нислэгийн удирдагч
3	APPROACH	Нислэгийн удирдагч
4	AGL	Нислэгийн удирдагч
5	SMC	Нислэгийн удирдагч
6	SUPERVISOR	Нислэгийн удирдагч
7	TECH	Нислэгийн удирдагч

COMPACT 3 GAREX 220 (Analog Telephone)

№	СУВГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	7100	Нислэгийн удирдагч
2	7101	Нислэгийн удирдагч
3	7102	Нислэгийн удирдагч
4	7103	Нислэгийн удирдагч
5	7104	Нислэгийн удирдагч
6	7105	Нислэгийн удирдагч
7	NOTAM шууд /hotline/	Нислэгийн удирдагч
8	Гал шууд	Нислэгийн удирдагч

Хавсралт-Ж(2)

SCREEN IMAGES and Video Display

№	СУВГИЙН НЭР	ДУГААР	ТАЙЛБАР
1	Video Grabber-1	1	Ажиглалтын өгөгдлийн дэлгэцийн бичлэг
2	Video Grabber-2	2	Ажиглалтын өгөгдлийн дэлгэцийн бичлэг

Хавсралт-Ж(3)

VoIP ТООН УТАС

№	СУВГИЙН НЭР	ДУГААР	ТАЙЛБАР
1	GP Shed	7128-7259	ХНАҮБ-ын глиссадын радио дохиологчийн төхөөрөмжийн байр
2	Цаг уур	7128-7260	Цамхагийн цаг уурын синоптик инженер
3	DVOR/DME	7128-7261	ХНАҮБ-ын Азимутын радио дохиологч ба зай хэмжих төхөөрөмжийн байр
4	Tech room 1	7128-7262	Цамхагийн НХУ-ын ярианы өрөө
5	Tech engineers	7128-7263	Цамхагийн НХУ-ын холбооны ээлжийн инженер
6	Voice Recorder	7128-7264	Цамхагийн НХУ-ын нислэгийн ярианы бичлэгийн системийн өрөө
7	Tech room 2	7128-7265	Цамхагийн НХУ-ын холбооны тоног төхөөрөмжийн байр
8	LLZ Shed	7128-7266	Суултын системийн курсын радио дохиологчийн төхөөрөмжийн байр
9	Цахилгааны ээлжийн инженер	7128-7267	Цамхагийн дэд өртөөний цахилгааны ээлжийн инженер

10	TWR-1	7128-7268	Нислэгийн удирдагч
11	TWR-2	7128-7269	Нислэгийн удирдагч
12	TWR-3	7128-7270	Нислэгийн удирдагч
13	Supervisor	7128-7271	Нислэгийн удирдагч (Supervisor)
14	Ээлжийн ахлах инженер	7128-7272	ХНАУБ-ын ээлжийн ахлах инженер
15	VHF станцын өрөө	7128-7273	Цамхагийн хэт богино долгионы станцын өрөө
16	GP Substation	7128-7277	Глиссадын дэд өртөө
17	LLZ Substation	7128-7278	Курсын дэд өртөө
18	Цаг уур	7128-7279	Цаг уурын синоптик инженер
19	Notam-1	7128-7280	НМУБ-ын мэдээллийн мэргэжилтэн-ARO
20	Notam-2	7128-7281	НМУБ-ын мэдээллийн мэргэжилтэн (Supervisor)
21	Notam-3	7128-7282	НМУБ-ын ахлах мэргэжилтэн
22	Notam-4	7128-7283	НМУБ-ын IT инженер

ЭФИР

№	СУВГИЙН НЭР	РАДИО ДАВТАМЖ	ТАЙЛБАР
1	Tower-Цамхагийн удирдлага	129,0 МГц	Радио VHF
2	SMC-Аэродром удирдлага	121,7 МГц	Радио VHF
3	Emergency	121,5 МГц	Радио VHF
4	Нислэгийн ярианы өрөө	-	Нислэгийн ярианы өрөө

АНАЛОГ УТАС

№	СУВГИЙН НЭР	ДУГААР	ТАЙЛБАР
1	Нислэгийн удирдагч	7128-7112	Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цамхаг)
2	Нислэгийн удирдагч	7128-7113	Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цамхаг)
3	Радио холбооны ээлжийн инженер	7128-7114	ХНАУБ-ын ээлжийн инженер
4	Навигацийн ээлжийн инженер	7128-7115	ХНАУБ-ын ээлжийн инженер
5	Ажиглалтын ээлжийн инженер	7128-7118	ХНАУБ-ын ээлжийн инженер
6	Цахилгааны ээлжийн инженер	7128-7119	ХНАУБ-ын ээлжийн инженер
7	Ээлжийн ахлах инженер	7128-1523	ХНАУБ-ын ээлжийн ахлах инженер
8	Ээлжийн ахлах инженер	70049859	ХНАУБ-ын ээлжийн ахлах инженер
9	Ерөнхий нислэгийн удирдагч	7128-1524	Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цамхаг)
10	Ерөнхий нислэгийн удирдагч	70049883	Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цамхаг)
11	NOTAM-1	7128-7129	НМУБ-ын мэдээллийн мэргэжилтэн (ARO)
12	NOTAM-2	7128-7130	НМУБ-ын мэдээллийн мэргэжилтэн (Supervisor)

ТООН УТАС

№	СУВГИЙН НЭР	ДУГААР	ТАЙЛБАР
1	Ээлжийн ахлах инженер	7128-7004	ХНАҮБ-ын ээлжийн ахлах инженер
2	Радио холбооны ээлжийн инженер	7128-7003	ХНАҮБ-ын ээлжийн инженер
3	Мэдээллийн технологийн ээлжийн инженер	7128-7001	ХНАҮБ-ын ээлжийн инженер
4	Навигацийн ээлжийн инженер	7128-7054	ХНАҮБ-ын ээлжийн инженер

Хавсралт-Ж(4)

ДҮРС БИЧЛЭГИЙН ТӨРӨӨХӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	КАМЕРИЙН НЭР	КАМЕРИЙН БАЙРШИЛ
1	Төхөөрөмжийн өрөө 1	НХУ-ын цамхагийн байр-№106
2	Төхөөрөмжийн өрөө 2	НХУ-ын цамхагийн байр -№106
3	Төхөөрөмжийн өрөө 3	НХУ-ын цамхагийн байр -№107
4	Нислэгийн ярианы бичлэгийн системийн өрөө	НХУ-ын цамхагийн байр -№209
5	Хэт богино долгионы станцын өрөө	НХУ-ын цамхагийн байр -№303
6	2 давхрын коридор	НХУ-ын цамхагийн байр-2 давхрын коридор
7	1 давхрын коридор	НХУ-ын цамхагийн байр-1 давхрын коридор
8	1 давхрын коридор	НХУ-ын цамхагийн байр-1 давхрын коридор
9	Цамхагийн дэд өртөө коридор	НХУ-ын цамхагийн байр цахилгааны дэд өртөө
10	UPS өрөө	НХУ-ын цамхагийн байр -1 давхар

---000---

БИЧЛЭГ АШИГЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС- №...

Хүсэлт гаргагч бөглөнө:		
1	Бичлэг ашиглах зорилго	Осол, ноцтой зөрчилтэй холбоотой Нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба, НХҮБ цаашид хадгалах хүсэлт гаргасан НХҮБ-ын ажилтны ур чадварыг үнэлэх, нислэгийн хөдөлгөөний удирдлагад дүн шинжилгээ хийх зэрэг албаны дотоод үйл ажиллагаанд ашиглах Нислэгийн хөдөлгөөний удирдлагын сектор, бүсийн багтаамж, нэвтрэн өнгөрүүлэх чадварыг тооцоолох, тодорхойлох Аливаа технологийн маргааныг шийдвэрлэх, дүгнэлт гаргах Техник, технологийн ажиллагаа хэвийн эсэхийг хянах
2	Бичлэгийн төрөл АТМ бичлэг Радио холбооны бичлэг Телефон ярианы бичлэг Камерын бичлэг	Хэрхэн хэрэглэх ✓ <i>тэмдэглэгээ хийнэ</i> үзэх сонсох хуулбарлах хадгалах устгах үзэх
3	Суваг	
4	Бичлэгийн хугацаа	Бичлэг эхлэх:он.....сар.....өдөр.....цаг.....мин Бичлэг дуусах:он.....сар.....өдөр.....цаг.....мин
Хүсэлт гаргасан:		
Албан тушаал /нэр гарын үсэг		
Зөвшөөрөл олгогч бөглөнө:		
Зөвшөөрсөн эсэх	о	Зөвшөөрнө
Зөвшөөрсөн	о	Зөвшөөрөхгүй
Бичлэг эхлэх огноо: он сар өдөр цаг мин		
Бичлэг дуусах огноо: он сар өдөр цаг мин		

Зөвшөөрөл олгосон: НТОЗШША-ны ☐Ерөнхий шинжээч ☐Шинжээч
/тамга/ нэр /гарын үсэг/
/.....он.....сар.....өдөр/

БИЧЛЭГ ҮЗСЭН, СОНССОН, ХУУЛБАРЛАСАН БАРИМТ

Бичлэгийн системийн инженер бөглөнө:	
үзсэн сонссон хуулбарласан хадгалсан устгасан	Бичлэг эхлэх:он.....сар.....өдөр.....цаг.....мин Бичлэг дуусах:он.....сар.....өдөр.....цаг.....мин Бичлэгийн төрөл:
Бичлэгийн системийн инженер.....он.....сар.....өдөр.....цаг.....мин	
Бичлэг ашигласанон.....сар.....өдөр.....цаг.....мин нэр гарын үсэг	
Энэхүү зөвшөөрлийн хуудасны эх хувь нь бичлэгийн төхөөрөмж хариуцсан инженерт хадгалагдана	

БИЧЛЭГ АШИГЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Хүсэлт гаргагч бөглөнө:		
1	Бичлэгийг ашиглах зорилго	
2	Зөвшөөрөл	Нислэгийн хөдөлгөөний удирдлагад дүн шинжилгээ хийх; Тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн эсэхийг хянах; НХҮ-ний ажилтнуудын харилцан ажиллагаанд дүн шинжилгээ хийх; Бусад;
3	Бичлэгийн төрөл	Хэрхэн хэрэглэх <i>✓тэмдэглэгээ хийнэ</i>
	АТМ бичлэг	үзэх
	Радио холбооны бичлэг	сонсох
	Телефон ярианы бичлэг Камерын бичлэг	хуулбарлах
4	Суваг	Бичлэгийн хугацаа
		Бичлэг эхлэх:он.....сар.....өдөр.....цаг.....мин
		Бичлэг дуусах:он.....сар.....өдөр.....цаг.....мин
		Бичлэгийн суваг.....
Хүсэлт гаргасан:		
Албан тушаал /нэр..... гарын үсэг.....		
Зөвшөөрөл олгогч бөглөнө:		
Зөвшөөрсөн эсэх	о	Зөвшөөрнө о
Зөвшөөрсөн:		
Бичлэг эхлэх огноо:.....он.....сар.....өдөр.....цаг.....мин		
Бичлэг дуусах огноо:.....он.....сар.....өдөр.....цаг.....мин		

Зөвшөөрөл олгосон: НААХЗА-ны ААНХХ-ийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч

/тамга/ нэр /гарын үсэг/ /.....он.....сар.....өдөр/

БИЧЛЭГ ҮЗСЭН, СОНССОН, ХУУЛБАРЛАСАН БАРИМТ

Бичлэгийн системийн инженер бөглөнө:	
үзсэн	Бичлэг эхлэх:он.....сар.....өдөр.....цаг.....мин
сонссон	Бичлэг дуусах:он.....сар.....өдөр.....цаг.....мин
хуулбарласан	Бичлэгийн төрөл:
Бичлэгийн системийн инженер.....он.....сар.....өдөр.....цаг.....мин	
Бичлэг ашигласанон.....сар.....өдөр.....цаг.....мин	
нэр гарын үсэг	
Энэхүү зөвшөөрлийн хуудасны эх хувь нь бичлэгийн төхөөрөмж хариуцсан инженерт хадгалагдана.	